# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр Дугаар А/14 Онги

Төсвийн зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолын 3,8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, 32.1.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.2.1 (г) дэх хэсгүүд, аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт өвөлжилт хүндэрч улмаар Улсын хэмжээнд өндөржүүлэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан зудийн эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах зорилгоор Орон нутгийн төсвийн давсан орлогоос 9,400,000 (Есөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөд тусган зарцуулсугай.

2.Засаг даргын нөөц хөрөнгөд тусгагдсан 9,400,000 төгрөгийг хуулийн дагуу зарцуулж, ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Р.Тунгалагтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЛУВСАНРАГВА

D disk /2024on/A Zahiramj.doc

482401014